

МОНГОЛ-АВСТРИЙН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТАРСАН КОМИССЫН ДӨРӨВДҮГЭЭР
ХУРАЛДААНЫ ҮЕЭР БАЙГУУЛСАН ТОХИРОЛЦОО

Монгол, Австрийн Эдийн засгийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын дөрөвдүгээр хуралдаан 2010 оны 2 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд Вена хотноо болов.

Хуралдааны үеэр хоёр тал дараах асуудлуудыг тохиролцов. Үүнд:

1. Сибири, Хойд Хятадын зах зээл чиглэсэн хамтарсан аж ахуйн нэгж, компанийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулахыг дэмжих чиглэлээр хоёр тал хамтран ажиллах боломжуудыг гүнзгийрүүлэн судлах үүднээс хоёр орны Эдийн засгийн танхимаар ахлуулсан хамтарсан ажлын хэсэг байгуулахыг санал болгох. Үүнтэй холбогдуулан ажлын хэсгийн судалгааны дүгнэлт, саналыг Эдийн засгийн хамтын ажиллагааны комиссын ээлжит 5 дугаар хуралдааны үеэр танилцуулахыг хоёр тал санал болгов.

2. Эрчим хүч, дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбарт дараах төслүүдийг хэрэгжүүлэхээр хоёр тал тохиролцов. Үүнд:

- Дулааны цахилгаан станцад нүүрсний утааг механик болон химийн аргаар шүүдэг Австрийн туршлага, техник, технологийг Монгол Улсад нэвтрүүлэх төсөл.
- Улаанбаатар хотод хог боловсруулан цахилгаан, дулаан гаргах үйлдвэр барих төсөл.
- Улаанбаатар хотын цэвэр, бохир усны хоолойг шинэчлэх шуудуугүй технологи нэвтрүүлэх.
- Монгол Улсын Хавдар судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл.
- Өтгийг бордоо болон цахилгаан үйлдвэрлэхэд ашиглах технологийг хамтатгасан Усалгаатай газар тариалангийн загвар аж ахуй байгуулах төсөл.

Тохиролцоог 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдөр Вена хотноо англи хэл дээр хоёр эх хувь үйлдэж, гарын үсэг зурав.

МОНГОЛЫН ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

АВСТРИЙН ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

ТҮНЖИН БАДАМЖУНАЙ

ЙОЗЕФ МАЙЕР

МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

ХОЛБООНЫ ЭДИЙН ЗАСАГ, ХӨДӨЛМӨР,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ГАДААД ЭДИЙН
ЗАСГИЙН БОДЛОГО, ЕВРОПЫН
ИНТЕГРАЦЛАЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
ДЭД САЙД